

## Цаг уур, уур амьсгалын горимын мэдээ боловсруулах CLIWARE системийн талаарх сургалт

ЦУОШГ-ын даргын 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/121 тоот тушаалын дагуу Цаг уур, уур амьсгалын горимын мэдээ боловсруулах CLIWARE 2.1 системийн талаар сургалт 2017.10.16-2017.10.20-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдсан.

Сургалтад тус төвийн Сүлжээ мэдээллийн сангийн инженер болон төв, орон нутгийн архив мэдээллийн дэд сангийн зохицуулагч нар хамрагдсан. Сургалтаар CLIWARE 2.1 системийн өгөгдлийн сангийн бүтэц, зохион байгуулалт, шуурхай болон горимын мэдээ хүлээн авах, боловсруулах, өгөгдлийн сан үүсгэх, ашиглах талаар онол, дадлагын ажил хийгдсэн.

Сургалтыг ЦУОШГ-ын Архив, мэдээллийн сангийн хэлтсийн мэргэжилтнүүд болон, Оросын холбооны улсын “Бүх Оросын Ус цаг уурын судалгаа, мэдээллийн хүрээлэн – Дэлхийн мэдээллийн төв” байгууллагын мэргэжилтэн А.В.Безпрозванных удирдан зохион явуулсан.

